БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Я.АМАРЖАРГАЛ

НИЙЛҮҮЛЭГЧ

МӨНХИЙН ТУН ХХК-НИЙ ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Ц.АЛТАНЦЭЦЭГ

# КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ҮЕД ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ШААРДЛАГАТАЙ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ ОНОШЛУУР НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № 142

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас Мөнхийн тун ХХК (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 05 дугаар сарын 11-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1 Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээг (цаашид "бараа" гэх) 22,600,000 (хорин хоёр сая зургаан зуун мянга) төгрөгөөр (цаашид "гэрээний үнэ" гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хүснэгт 1. Нийлүүлэх бараа

| Д/Д | Барааны нэр, төрөл | Багцийн дугаар | Үйлдвэрлэгч, Улс | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгж үнэ /НӨАТ орсон/ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Умифеновир | 1 | Фармстандарт, ОХУ | Шахмал | 14 000 | 1 500 | 21 000 000 |
| 2 | Ацетаминофен | 3 | Мөнхийн Тун ХХК, Монгол | Шахмал | 40 000 | 40 | 1 600 000 |
| | Нийт дүн | | | | | | **22 600 000** |

1. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг **22,600,000** (хорин хоёр сая зургаан зуун мянга) төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөр санхүүжүүлнэ.

2. Нийлүүлэгч нь 2 нэр төрлийн эмийг 2020 оны 05 дугаар сарын 11-ны өдрөөс 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

3. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг[1];
Тендер ба үнийн хуваарь;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

4. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

5. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

6. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Хүснэгт 2. Санхүүжилтийн хуваарь

| Д/Д | Барааны нэр, төрөл | Багцийн дугаа | Урьдчилгаа /төгрөг/ | Гүйцэтгэл /төгрөг/ |
|---|---|---|---|---|
| 1 | Умифеновир | 1 | 0 | 21 000 000 |
| 2 | Ацетаминофен | 3 | 0 | 1 600 000 |
| | **Нийт дүн** | | **0** | **22 600 000** |

Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нєхцєлд оруулсан зайлшгїй шаардлагатай нэмэлт, єєрчлєлтїїд.

| | |
|---|---|
| **25. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах (ГЕН-ийн Зүйл 25)** | |
| ГЕН 25 | ГЕН-ийн 25-т хамаарах тусгай нөхцөл байхгүй |
| **26. Маргааныг шийдвэрлэх (ГЕН-ийн Зүйл 26)** | |
| ГЕН 26 | ГЕН-ийн 26-д хамаарах тусгай нөхцөл байхгүй |
| **27. Гэрээнд ашиглах хэл (ГЕН-ийн Зүйл 27)** | |
| ГЕН 27.1 | Монгол хэл |
| **28. Гэрээнд мөрдөх хууль(ГЕН-ийн Зүйл 28)** | |
| ГЕН 28.1 | Гэрээнд Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөнө |
| **29. Мэдэгдэл (ГЕН-ийн Зүйл 29)** | |
| ГЕН 29.1 | Эрүүл мэндийн яам, Засгийн газрын 8 дугаар байр, Улаанбаатар-48, Олимпийн гудамж-2 |
| **30. Татвар, хураамж (ГЕН-ийн Зүйл 30)** | |
| ГЕН 30 | Монгол Улсын нутаг дэвсгэрийн гаднаас болон дотоодоос нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодисыг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн ХӨСҮТ-д болон эцсийн цэгт захиалагчид хүргэх хүртэл оногдуулсан бүх татвар хураамж, тээвэр, даатгал болон бусад зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна. |

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

**Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгсэл,** үйлдвэрлэлийн хэлтсийн дарга
.......................................Г.Цэцэнсанаа

**Эрүүл мэндийн яамны** Хөрөнгө оруулалтын **хэлтсийн** дарга
.......................................Т.Бямбасүрэн

**Эрүүл мэндийн яамны** Эм, эмнэлгийн **хэрэгсэл,** үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн
.......................................Т.Мөнхтуул

**Эрүүл мэндийн яамны** Хөрөнгө оруулалтын **хэлтсийн** мэргэжилтэн
.......................................Г.Бат-Эрдэнэ

**Эрүүл мэндийн яамны** ахлах нягтлан **бодогч**
.......................................Г.Догсмаа

**Эрүүл мэндийн яамны** хуулийн хэлтсийн **мэргэжилтэн**
.......................................Д.Мөнхцэцэг

***210 Ул**аанбаатар хот Сүхбаатар*
***дүүрэг** Олимпийн гудамж 2, Засгийн газрын*
***II байр***

***Утас:26**3695*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Мөнхийн тун ХХК-ийн Эдийн засагч
.......................................Б.Батгариг

*Монгол Улс, Улаанбаабаатар хот, Баянзүрх дүүрэг, Шар хад, Да хүрээ гудамж, 29-1 тоот*

*Утас: 70115653*

*Харилцах банк:* ***Капитрон*** *3053001197*